

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.130

Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Тэмээний ноос. Техникийн шаардлага	MNS 0036 : 2007 MNS 0036 : 2001-ийн оронд
<i>Textiles. Grease camel wool. Technical specification</i>	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандарт нь тэмээний ноосыг бэлтгэж, хүлээн авахад хамаарна.

2. Нэр томъёо, тодорхойлолт

2.1 Торомны ноос (*Baby camel wool*) - гурав хүртэл насны тэмээний, уян хатан, бат бэх, туг үснүүд нь богино, зөөлөн ноос;

2.2 Их биеийн ноос (*Fine wool*) - гурваас дээш насны тэмээний бөөр, дал хажуугийн, бат бэх ноос;

2.3 Зогдор ноос (*Coarse wool*) - урт бүдүүн ширхэгтэй, тэмээний шил, хоолой, өвдөг, бөхний оройн хэсгийн ноос;

2.4 Хэвийн ноос (*Regular fleece wool*) – 3 % хүртэл, хялбар ялгагдахгүй, ургамлын болон эрдсийн гаралтай хогт хольцтой ноос;

2.5 Хогтой ноос (*Wasty wool*) – 3 %-иас дээш өвс, шивээ, зангуу, өргөс, эрдэс хольц, элс шороо, хужир, борзонтой ноосыг хэлнэ.

3. Ангилал

3.1 Тэмээний ноосыг дараах байдлаар ангилна.

3.1.1 Насны ялгаа, ноосны бүтэц, чанараар нь:

- а/ торомны;
- б/ их биеийн;
- в/ зогдор

3.1.2 Өнгөөр нь:

- а/ цагаан шаргал;
- б/ бор шаргал;
- в/ хүрэн

3.1.3 Гадаад байдал, бохирдолтоор нь:

- а/ хэвийн;
- б/ хогтой гэж ангилна.

4. Техникийн шаардлага

4.1 Ноосны чанар 1 дүгээр хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

1 дүгээр хүснэгт

Д/д	Ноосны төрөл	Ширхэгтийн дундаж нарийн, мкм	Үндсэн шаардлага
1	Торомны	23,0 хүртэл	80 %-иас дээш ноолууртай
2	Их биеийн	23,1-35,0	60 %-иас дээш ноолууртай.
3	Зогдор	35,01-ээс дээш	бага зэргийн ноолууртай, ширүүн

4.2 Тэмээний ноосны өнгө 2 дугаар хүснэгтэд заасан тодорхойлолтод тохирч байна.

2 дугаар хүснэгт

Д/д	Өнгө	Тодорхойлолт
1	Цагаан шаргал	Ноолуур, сор үс нь цагаан, шаргал, цайвар
2	Бор шаргал	Ноолуур нь цайвар шаргал, сор үс нь ухаа, улбар шаргал
3	Хүрэн	Улаан, хар хүрэн, бор өнгийн ноос холилдсон.

4.3 Тэмээний ноосны хэвийн чийглэг (15±1)% байна.

5. Шалгаж, хүлээн авах

5.1 Тэмээний ноосны нийт жингийн 10 %-д чанарын шалгалт хийж, хүлээн авна. Шаардлагатай гэж үзвэл 100 %-ийн шалгалт хийнэ.

5.2 Тэмээний ноосны чанарын талаар гарсан маргааныг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

5.3 Тэмээний ноосны чанарыг тодорхойлохдоо дараах стандартыг мөрдөнө. Үүнд:

- 1) MNS 2951:2007 Ноос,ноолуур. Шинжилгээнд дээж авах арга;
- 2) MNS 4054:2007 Ноос, ноолуур. Урт тодорхойлох графикайн арга;
- 3) MNS 1000:2007 Ноос, ноолуур. Бичил дурангаар нарийн тодорхойлох арга;
- 4) MNS 1027:2007 Ноос, ноолуур. Хаг, хогт хольц тодорхойлох арга;
- 5) MNS 3961:2007 Ноос, ноолуур. Урт тодорхойлох тоолох арга.
- 6) MNS 380:2007 Ноос, ноолуур. Чийглэг тодорхойлох арга.
- 7) MNS 2949:2001 Ноосны бүрэлдэхүүн тодорхойлох арга.

6. Савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх

6.1 Тэмээний ноосыг “MNS 0215 : 2007 Ноос, ноолуур. Савлах, хаяглах, хадгалах журам”-ын шаардлагын дагуу савлаж, хаяглаж, хадгалж, тээвэрлэнэ.

ТӨГСӨВ.

